



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

2026 оныг “Бэлчээр ба нүүдлийн мал  
аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”  
болгон зарласантай холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг  
Үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2022 оны 03 дугаар  
сарын 15-ны өдрийн A/RES/76/253 дугаар тогтоолоор 2026 оныг “Бэлчээр ба  
нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил” болгон зарласантай  
холбогдуулан олон улс, дотоодын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний  
төлөвлөгөө боловсруулах, бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий  
Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захиралдаар байгуулсугай.

2. “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил”-ийн  
хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын  
газрын болон “Дэлхийн цаа бугын аж ахуй эрхлэгчдийн их хурал”-ын Ажлын алба,  
2026 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч талуудын 17 дугаар  
бага хурал”-ын Ажлын албаны үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж,  
хамтран ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур  
амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтuya, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр нарт тус тус үүрэг болгосугай



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.ЭНХБАЯР